

PIERCE COLLEGE

possibilities. realized.



ОЛОН УЛСЫН БОЛОВСРОЛ

- Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөр (IEP)
- Ассошиет Зэргээс Их Сургуульд Шилжин Орох Хөтөлбөр
- Ахлах Сургуулийг Түргэвчлэн Төгсөх Хөтөлбөр
- Богино-Хугацааны Хөтөлбөр



www.pierce.ctc.edu/IE



piercecollegeie



piercecollegeie



piercecollegeie




piercecollegeie



Вашингтон Мужтай Танилцах

- Пиерс Коллеж нь Вашингтон мужид байрладаг. Тус муж нь үзэсгэлэнтэй байгаль, цэвэр орчин болон технологийн өндөр хөгжилтэй эдийн засгаараа алдартай.
- Microsoft, Starbucks, Expedia, Alaska Airlines, Amazon болон REI зэрэг хэд хэдэн компанийн төв оффисууд байрладаг.
- Мэргэжлийн спортын багууд: Mariners (бейсбол), Seahawks (Америк хөлбөмбөг) ба Sounders (хөл бөмбөг)
- Байгалийн үзэсгэлэнт газрууд: үндэсний цэцэрлэгт хүрээлэнгүүд (Маунт Рейнир, Олимпик, Норт Каскейдс), Номхон Далайн Наран Шарлагын Газар, Каскейд Уулс, халуун орны ой болон гол мөрнүүд.
- Нэг ба түүнээс бага цаг явж хүрэх хотууд: Сиэтл, Такома, Олимпиа (мужийн нийслэл)
- Дөрвөн цаг явж хүрэх газрууд: Викториа ба Канадын Ванкувер, Портланд, Орегон, Номхон Далай
- Та Сиэтл-Такома Олон Улсын Нисэх Онгоцны Буудлаас АНУ-ын ихэнх том хотууд руу шууд нисэх боломжтой.
- Гадуурх зугаа цэнгэл: усан спорт, цасан спорт, явган аялал ба ууланд авирах зэргийг нэгээс хоёр цаг явж хүрэх газруудад хийх боломжтой





Пиерс Коллеж Форт Стэйлакүүм ба Пуялал

1967 онд байгуулагдсан; Америк дахь хоёр жилийн сургалттай орон нутгийн коллежуудын шилдэг 10 хувьд багтдаг; сургалтын чанар болон оюутнуудын амжилтаараа үндэсний хэмжээнд танигдсан; бүрэн магадлан итгэмжлэгдсэн, улсын коллеж бөгөөд ассошиет, бакалавр зэрэг болон мэргэжлийн сертификат олгох болон богино-хугацааны хөтөлбөрүүдийг санал болгодог.

Пиерс Коллеж нь хоорондоо 30 минутын зайтай явж хүрэх оюутны хоёр үзэсгэлэнт хотхонтой. Тус хотхонууд нь орчин үеийн олон барилга байгууламж, байгалийн үзэсгэлэн бүрдсэн уул толгод, суралцах таатай орчныг бүрдүүлсэн том саруулхан цонхтой. Хотхон бүр нь нөхөрсөг, аюулгүй бөгөөд таатай орчныг бүрдүүлсэн байна. Оюутнууд суралцах тав тухтай орчин, олон сонголттой хоолны заал, оюутны клубүүд, хөгжим болон спортын арга хэмжээ зэргийг санал болгосон таатай орчинтой оюутны хотхонд бүхэл өдрийг өнгөрөөх боломжтой.

Оюутны хотхоны байгууламжууд:

- Үндэсний хэмжээнд танигдсан, шилдэг номын сангууд
- Хамгийн орчин үеийн тоног төхөөрөмж бүхий компьютерын лаборатори
- Шинэ шинжлэх ухааны төв
- Үнэгүй интернэт
- Олон сонголттой хоолны заал
- Давтлагын болон эссе бичлэгийн танхим
- Үзүүлэх тоглолтын театр
- Фитнес төв
- Шинжлэх Ухааны Бөмбөгөр Оройт Төв болон одон орон судлалын төв

Шагнал:

Пиерс Коллеж нь нэр хүндтэй Аспен Институтээр үнэлэгдсэн, үндэсний хэмжээний шилдэг 10 орон нутгийн коллежийн нэг юм.



Пиерс Коллеж нь Мөрөөдлөө Биелүүлэхэд Тань Туслах Манлайлагч Коллеж гэж нэрлэгддэг бөгөөд оюутнуудад коллеждоо үлдэн, өөрсдийн суралцах зорилгодоо хүрэхэд тусалдаг байгууллага билээ.



Пиерс Коллеж нь оюутнуудын амжилтыг үнэлдэг үндэсний хэмжээний хоёр дахь том шагнал болох – Леа Мэйер Остины нэрэмжит шагналыг хүртсэн байна.



Пиерсэд суралцсан сүүлийн жилдээ би элсэхээр хүсэлт гаргасан бүх дөрвөн-жилийн сургалттай дээд сургуулиуддаа тэнцсэн. Үүнд миний мөрөөдлийн сургууль болох Нью-Йоркийн Их Сургуулийн Стерн Бизнесийн Сургууль багтана. Би НЙИС-ийн шилдэг оюутнаар төгссөн бөгөөд Уолл Стритэд бүртгэлтэй нэр хүндтэй компаниудаас хэд хэдэн ажлын санал хүлээн авсан. Пиерс Коллежод суралцсан маань надад ийм боломжийг авчирсан билээ.”

Йоцафон Сангил

Пиерс Коллеж болон Нью-Йоркийн Их Сургуулийн Тайланд Төгсөгч 2016 оны Пиерс Коллежийн Төгсөгчдийн Холбооны Шилдэг Төгсөгч



Оюутны амьдрал

Пиерс Коллеж нь оюутнуудад суралцах, найз нөхөдтэй болох болон коллежийн амьдралыг бүрэн дүүрэн эдлэх боломжийг олгодог. Бидний зорилго нь оюутнуудад оюутны амьдралынхаа туршлагыг өөрсдийн сургалтын амжилттай тэнцвэртэй хослуулахад туслах юм.

Бид оюутны хотхонд үйл ажиллагаа явуулдаг олон клубүүдтэй бөгөөд оюутнуудад зориулсан үйл ажиллагаануудыг явуулдаг. Заримаас нь дурдвал:



■ Үйлчилгээнээс суралцах төслүүд – Оюутнууд сайн дурын үйл ажиллагаанд оролцсоноор үнэлж баршгүй туршлага олж аван, нийгмийн хариуцлагаа ухамсарлах боломжтой

■ Цана, чаргаар гулгах, дэлгүүр хэсэх, хотын зугаалга, майхантай аялал хийх, тоглолт үзэх, музей үзэх зэрэг олон үйл ажиллагаанд оролцох боломжтой

■ Шинээр Төрөн Гарч Буй Манлайлагчдын Академи (ELA) нь оюутнуудад манлайлах чадвараа хөгжүүлэхэд нь тусалдаг

■ Олон Соёлт Манлайллын Институт (MLI) нь олон талт байдлыг таниулахыг уриалдаг

■ Бүх оюутнуудад зориулсан сонгууль Оюутны Засгийн Газар

■ Хамтлаг, найрал дуу эсхүл найрал хөгжимд орох

■ Театрын жүжигт тоглох эсхүл дижитал кино бүтээх

■ Бүх оюутнууд манай оюутны спортын багт орохын тулд өрсөлдөх боломжтой


■ Оюутны Элч болсноор бусад оюутнуудад туслах

■ K-Pop Club

■ Олон Улсын, Тайко болон Соёлын, Япон Тоглоом болон Үзвэрийн, Хөл Бөмбөгийн, Хүрээлэн Буй Орчны, Зохиолчдын, Хөгжим болон Жүжиглэх Урлагийн, Ширээний теннис, Бизнес болон Инженерингийн зэрэг олон клубт элсэх



Оюутны болон Сургуулийн Спортууд



Пиерс Коллеж нь Форт Стэйлакүүм ба Пуйалапын коллежийн тамирчин оюутнуудад Вашингтон, Орегон, Бритиш Коламбия болон Канад дахь 36 гишүүн коллежоос бүрдсэн Баруун Хойд Зүгийн Тамирчдын Зөвлөгөөний (NWAC) өндөр өрсөлдөөнтэй оюутны спортын наадамд оролцох боломжийг олгодог. Пиерс Коллежийн бүх оюутнуудад эдгээр өндөр өрсөлдөөнтэй коллежийн спортын багуудад элсэн орох үүд хаалга нээлттэй байдаг.

■ Эмэгтэйчүүдийн сагсан бөмбөг, хөл бөмбөг ба волейбол

■ Эрэгтэйчүүдийн бейсбол, сагсан бөмбөг ба хөл бөмбөг

Гадаад Оюутны Албаны Үйлчилгээ

Пиерс Коллежийн Гадаад Оюутны Алба нь дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн оюутнуудыг найрснаар хүлээн авдаг. Бид өөрсдийн оюутнууддаа амжилттай суралцаж, мэргэжлийн болон амьдралын зорилгоо биелүүлэх боломжоор хангагдахад туслах хамгийн боломжит үйлчилгээ болон туслалцааг үзүүлэх үүрэг амлалт хүлээсэн.

Манай ажилтнууд даяаршсан сэтгэхүйтэй бөгөөд бүгд гадаадад ажиллаж, амьдарч, суралцаж байсан туршлагатай. Бид оюутан бүрийн хувийн онцлогийг мэдэрч, тэдэнд өөрсдийн шинэ орчинд дасан зохицох болон АНУ-д коллегод суралцахад нь шаардагдах туслалцааг үзүүлэхэд хэзээд бэлэн байдаг.

Оюутнууд Пиерс Коллежод элсэн орсон мөчөөс бид тэднийг Пиерсийн гэр бүлийн нэг гишүүний хувиар нөхөрсгөөр угтан авдаг. Бидний зорилго нь оюутан бүрийг өөрсдийн мөрөөдлөө биелүүлэхэд нь туслах зааварчилгаа, тусламжаар хангах явдал билээ.




Бид дараах зүйлсээр хангадаг:

- 1 Сургуульд элсэн орох өргөдөл гаргах, элсэх болон визний материал бүрдүүлэлтийн талаар шат дараалсан хувийн зааварчилгаа өгөх
- 2 Онгоцны буудлаас тосох (хүрэлцэн ирэх өдрөө урьдчилан мэдэгдсэн үед үнэгүй)
- 3 Сургууль танилцуулах өдөрлөг болон угтах үдэшлэг
- 4 Гадаад Оюутнуудын Байр болон айлд байрлуулах зэргээр байрны асуудлыг шийдэж өгөх
- 5 Оюутны хотхон доторх ба гадуурх хөгжөөнт арга хэмжээ болон аяллууд
- 6 Шилжих оюутнуудад дэлгэрэнгүй зөвлөгөө өгөхийг багтаасан сургалтын болон хувийн ганцаарчилсан зөвлөгөө
- 7 Манай хамтын ажиллагаатай сургуулиудад болзолтойгоор элсэн орох баталгаа
- 8 Амжилт гаргасан оюутнуудыг урамшуулан, таниулах онцгой арга хэмжээ
- 9 Оюутнуудыг хоорондоо уулзах, нөхөрлөх болон холбоо харилцаа тогтоох боломжоор хангах
- 10 Амжилтанд хүрэхэд туслах семинар болон сургалтын боломжууд

Одоогоор суралцаж буй оюутнуудад зориулсан тэтгэлэг болон ажлын дадлага хийх боломж:

- 1 Оюутан элч тэтгэлэг
- 2 Гадаад Оюутны Сургалтын албаар дамжуулан оюутнууд сургалтын тэтгэлэгт хамрагдах хүсэлт гаргах боломжтой
- 3 Оюутнууд оюутны хотхон дотроо ажилд орж болох ба долоо хоногт 20 хүртэл цаг ажиллах боломжтой
- 4 Сургалтын албанаас оюутнуудын сонирхлыг татах олон төрлийн сэдвээр семинар зохион байгуулдаг





Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөр (IEP)

Пиерс Коллежийн Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөрт хамрагдах нь Англи хэлийг хурдан сурах хамгийн шилдэг арга бөгөөд өөрсдийн сургалтын хөтөлбөрүүдэд TOEFL эсвэл IELTS-ийн оноогүйгээр элсэх боломжийг олгодог.

Бид дараах зүйлсийг санал болгож байна:

- IEP хөтөлбөрийг төгссөнөөр Пиерс Коллежийн сургалтын курсүүдэд баталгаатай элсэн орох
- Хэзээд элсэх боломжтой; оюутнууд IEP эсвэл академик түвшний хөтөлбөрүүдэд жилд дөрвөн удаа элсэн орох боломжтой
- Анхан шатнаас гүнзгийрүүлсэн шат хүртэлх дөрвөн-түвшинтэй хөтөлбөр
- Долоо хоногт 20 цаг орох бүтэн цагийн танхимын хичээл
- Унших, бичих, сонсох, ярих болон дүрмийн Англи Хэлний Их Дээд Сургуульд Суралцагсад зориулсан хичээл
- Цөөн хүнтэй анги – нэг ангид 20-иос доош оюутан байх, дунджаар нэг анги 12-14 оюутантай байдаг
- Холбогдох чиглэлээр магистрын зэрэг эзэмшсэн, ESL мэргэжлийн зэрэгтэй, туршлагатай багш
- Оюутнууд хотхоны байгууламжуудад бүрэн нэвтрэх, ашиглах эрхтэй
- Хөтөлбөрт тусгагдсан дотоодын сонирхолтой газрууд руу аялах болон хөгжөөнт арга хэмжээнд хамрагдах
- Манай Харилцан Ярианы Найз нэртэй алдартай хөтөлбөрөөр дамжуулан Америк оюутнуудтай нөхөрлөх
- Давтлагын төвд зочилсноор хичээлдээ үнэгүй туслалцаа авах



“Би анх Пиерс Коллежийн Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөрт хамрагдсан. Гайхамшигтай багш нарын ачаар бүх хичээлүүд маш сонирхолтой явагдаж байсан. Надад бас Харилцан Ярианы Найз нэртэй хөтөлбөр үнэхээр таалагдсан. Америк оюутнуудтай харилцан яриа өрнүүлснээр Англи хэлийг хурдан сурахад их тус болсон. Би одоо Англиар өөртөө итгэлтэйгээр ярьдаг болсон.”

Ти Нгуээн, Вьетнам

Англи Хэлний Эрчимжүүлсэн хөтөлбөрт суралцагч

Богино хугацааны хөтөлбөр:

Бид жил бүр дөрвөн-долоо хоногийн Англи хэлний эрчимжүүлсэн хөтөлбөр коллежод амжилттай элсэн ороход туслах хөтөлбөрүүдийг санал болгодог.

Ассошиет Зэрэг ба Их Сургуульд Шилжин Орох Хөтөлбөр

Оюутнууд манай хамтын ажиллагаатай их дээд сургуулиудад болзолтойгоор баталгаатай шилжин орох болон өөрсдийн сонгосон их дээд сургуулиудад элсэх хүсэлт гаргахынхаа өмнө хоёр жилийн ассошиет зэрэг эсвэл ерөнхий зэргийн хөтөлбөрийг төгсөх боломжтой.

Суралцах Чиглэлүүд

Дараах мэргэшлүүдээр дөрвөн-жилийн сургалттай сургуулиудад суралцах боломжтой

- Антропологи
- Археологи
- Урлаг
- Одон орон судлал
- Агаар Мандлын Шинжлэх Ухаан
- Биологи
- Бизнесийн шилжилт
 - Нягтлан бодох бүртгэл
 - Удирдлага
 - Санхүү
 - Менежмент
- Хими
- Харилцаа Холбоо Судлал
- Барилгын Менежмент
- Эрүүгийн Хэргийн Хууль Сахиулах
- Дижитал Дизайн
- Дижитал Кино
- Драм
- Эдийн засаг
- Боловсрол
- Инженеринг
 - Нисэх Хүчин
 - Био инженеринг
 - Химийн
 - Иргэний
 - Компьютер
 - Цахилгаан
 - Хүрээлэн буй орчин
- Үйлдвэрлэл
- Материал
- Механик
- Англи хэл
- Хүрээлэн Буй Орчны Шинжлэх Ухаан
- Гадаад Хэл
 - Америкийн Дохионы Хэл
 - Франц
 - Солонгос
 - Испани
- Газарзүй
- Геологи
- Эрүүл Мэндийн Боловсрол/Эрүүл амьдрах
- Эрүүл Мэндийн Шинжлэх Ухаан
 - шүдний эмчийн-бэлтгэл
 - анагаахын-бэлтгэл
 - сувилахуйн-бэлтгэл
 - сэргээн засах эмчилгээний-бэлтгэл
 - эм зүйчийн-бэлтгэл
 - физик эмчилгээний-бэлтгэл
- Түүх
- Хүмүүнлэгийн ухаан
- Хүнд Зориулсан Үйлчилгээ болон Сэтгэгдэд Нөлөөлөх Бэлдмэлийн Хорыг Таниулах
- Сэтгүүл зүй
- Хөдөлгөөн судлал
- Хууль (бэлтгэл-)
- Математик
- Микробиологи
- Хөгжим
- Далайн зураг авалт
- Философи
- Биеийн Тамир
- Физик
- Улс Төрийн Шинжлэх Ухаан
- Сэтгэл судлал
- Нийгмийн Үйлчилгээ/Оюуны Эрүүл Мэнд
- Социологи



Бакалаврын Онцгой Хөтөлбөрүүд

(элсэхэд тусгай шаардлага болон хязгаарлалтуудтай)

- Бага Насны Хүүхдийн Боловсрол
- Амны Хөндийн Ариун Цэвэр
- Улс Орны Аюулгүй Байдал

Recent Pierce College International graduates have transferred to top universities throughout the USA, including:

- University of Washington
- University of Massachusetts
- Columbia University
- New York University
- Purdue University
- University of Wisconsin
- Pepperdine University
- University of Florida
- University of Illinois
- Rutgers University
- University of Michigan
- Portland State University
- Indiana University
- Arizona State University
- University of California at Davis / San Diego / Irvine Los Angeles / Berkeley

* Many other universities offer conditional guaranteed admission to Pierce students



“Би 2018 онд Колумбын Их Сургуульд элсэж чадсан.”

**Жошуа
Рю, Хон Жае**

“Би 2018 онд Purdue Их Сургуульд элсэж чадсан.”

**Жэй
Чой, Жи-Хён**



Ахлах Сургуулийг Түргэвчлэн Төгсөх Олон Улсын Хөтөлбөр

Өөрийн эх орондоо ахлах сургууль төгссөн гэрчилгээ аваагүй гадаад оюутнууд Пиерс Коллежод ахлах сургуулиа төгсөн, гэрчилгээ авах бүрэн боломжтой. Хичээл эхлэх үед 16 нас хүрсэн байх шаардлагатай.

Ахлах Сургуулийг Түргэвчлэн Төгсөх Хөтөлбөрт хамрагдсанаар хоёр үндсэн давуу талтай:

1

Цаг хугацаа болон зардал хэмнэх

Түргэвчлэн Төгсөх Олон Улсын хөтөлбөрт хамрагдсан оюутнууд ахлах сургуулиа төгсөхөөс өмнө коллежод элсэх боломжтой. Оюутнууд Вашингтон мужийн ахлах сургуулийн гэрчилгээ эзэмшихээс гадна ассошиет зэрэг рүү чиглэсэн коллежийн кредит цуглуулах боломжтой.

2

Амжилтанд хүрэх бэлтгэл хийх

Оюутнууд дөрвөн жилийн сургалттай их дээд сургуульд элсэн орохоосоо өмнө суралцах ур чадвар эзэмшин, Америкийн соёлын талаар таньж мэдэн, АНУ-ын боловсролын системд дасан зохицох чадвартай болно.


Хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа нь тухайн оюутны Англи хэлний түвшин болон ахлах сургуулийн дүнгээс хамаарна. Оюутан бүрийн нөхцөл байдал өөр байх боловч ихэнх оюутнууд хөтөлбөрөө 2-2.5 жилийн хугацаанд дуусгадаг бөгөөд бакалаврын зэрэг эзэмшихээр их дээд сургууль руу шилжин суралцдаг.



“

Ахлах Сургууль Төгсөх Хөтөлбөрөөр дамжуулан би ахлах сургуулийн гэрчилгээ болон ассошиет зэргээ маш хурдан авсан төдийгүй бакалаврын зэрэг эзэмшихээр их сургуульд шилжин суралцах боломжтой болсон. Би Жорж Мэйсон Их Сургуульд тэнцсэн бөгөөд бакалаврын зэргээ тэнд эзэмшихээр болоод байна!”

Эрим Пала, Турк
Ахлах Сургууль
Төгсөх Хөтөлбөр



Байрны Сонголтууд

Оюутнууд оюутны байр эсвэл айлд амьдрах боломжтой. Аль ч сонголтыг хийсэн найз нөхөдтэй болох, Англи хэлээ давтах болон Америкийн соёлын талаар танин мэдэх бүрэн боломжоор хангагдана.



Гадаад Оюутнуудын Байр (CGS)

Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн оюутнуудтай нөхөрлөх замаар олон орны соёл, зан заншилтай танилцан, хөгжөөнтэй арга хэмжээнүүдэд оролцон, сургалтын амжилтаа ахиулан, бие даах чадварт суралцах боломжтой. Оюутнууд кодоор онгойдог аюулгүй, бүрэн хамгаалалттай байранд амьдрах бөгөөд байнга байрладаг ажилтнууд хэзээд туслахад бэлэн байна.

CGS нь дараах зүйлстэй:

- Интернет холболт
- Нийтийн гал тогоо
- Хичээл давтах өрөө
- Байран доторх угаалгын газар
- ТВ/тоглоомын өрөө
- Нийтийн тээвэртэй ойрхон

Бүх өрөө нь дараах зүйлстэй:

- Өргөн ор
- Жижиг хөргөгч
- Хувцасны шүүгээ
- Ширээ, сандал
- Wi-Fi

Байрны Төлбөр

Гурван хүний өрөө: сард \$567
Хоёр хүний өрөө: сард \$700
Нэг хүний өрөө: сард \$867



Айлд байрлах

Америк гэр бүлд амьдарснаар Америкийн соёл болон амьдралтай танилцах боломжтой. Айлд амьдрах нь өөр орны соёл, зан заншилтай танилцах болон насан туршийн нөхөрлөлийг бий болгох зорилготой юм. Оюутнууд сар бүрд амьдрах зардал болгон тухайн айлдаа төлбөр төлнө.

Бүх айл дараах зүйлсээр хангадаг:

- Цагаан хэрэглэлтэй ор
- Ширээ болон ширээний чийдэн
- Оюутнуудад амжилттай суралцахад нь дэмжлэг үзүүлэхүйц нөхөрсөг орчин
- Нийтийн тээвэрт ойр, оюутны хотхонд ойр байрлалтай
- Wi-Fi

Айлд байрлах зардал

Хоолгүй өрөө: сард \$500
Өдрийн 2 хоолтой өрөө: сард \$650



Байр сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх вэбсайтаас аваарай:
www.pierce.ctc.edu/ie-housing

Пиерс Коллежод Элсэх Үйл Явц

Та Пиерс Коллежод элсэх өргөдлийг хэдийд ч гаргах боломжтой. Тусгайлан товлосон “Өргөдөл Хүлээн Авах Огноо”-г баримталснаар та визээ аваад, АНУ руу ирэн, амьдрах байр сууцны талаар хамгийн боломжит сонголтуудыг эдлэхэд шаардагдах хангалттай хугацаатай байхад тусална.

- 1 Элсэхэд өөрт хамгийн тохиромжтой үеэ сонгох. Манай хөтөлбөрүүд жилд дөрвөн удаа эхэлдэг (доорх хүснэгтийг харна уу)
- 2 Өргөдлөө бөглөж дууссан бол танд 48 цагийн дотор хүлээн авсан хариу ирнэ
- 3 DHL-ээр I-20 маягт хүлээн авч, SEVIS хураамжаа төлөөд, өөрийн улс дахь АНУ-ын Элчин Сайдын Яаманд визний ярилцлагаа товлох
- 4 Амьдрах байрны асуудлаар бүртгүүлэх
- 5 Хичээл эхлэхээс дор хаяж нэг долоо хоногийн өмнө АНУ-д ирсэн байхаар онгоцны билет худалдан авах
- 6 Онгоцны буудал дээр тосуулах (зөвхөн бидний тохиромжтой үед ирсэн тохиолдолд үнэгүй – элсэх үедээ тодруулаарай)
- 7 Онгоцны буудлаас байрандаа ирээд, шинэ гэртээ төвхнөх
- 8 Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөр эсвэл бусад сургалтын курсүүдэд хамрагдахын тулд түвшин тогтоох шалгалт өгөөд, бүртгүүлэх
- 9 Сургууль танилцуулах албан ёсны өдөрлөг, угтах үдэшлэгт оролцон, клубт элсэн, үйл ажиллагаануудад оролцон, найз нөхөдтэй болох
- 10 Сургалтын төлбөрөө төлөөд, хичээлээ эхлэх

Open start dates

Spring 2019 - April 8

Summer 2019 - July 6

Fall 2019 - Sept 23

Winter 2020 - Jan 6

Spring 2020 - April 6

2019–2020 оны Хичээлийн Жилийн Барагцаалсан Төлбөр

Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөр			Академик Түвшний Ангиуд	
Төрлүүд	Улирлаар (3 сар)	Хичээлийн Жил (9 сар)	Улирлаар (3 сар)	Хичээлийн Жил (9 сар)
Төлбөр, хураамж*	\$2,750	\$8,250	\$3,257	\$9,771
Ном, материал	\$250	\$750	\$300	\$900
Эрүүл мэндийн даатгал	\$331	\$993	\$331	\$993
Байр, хоол \$650/сард	\$1,950	\$5,850	\$1,950	\$5,850
Хувийн зардал	\$750	\$2,250	\$750	\$2,250
Нийт зардал (ойролцоо)	US \$6,031	US \$ 18,093	US \$6,588	US \$19,764

*Академик түвшний сургалтын төлбөр болон хураамж нь 15 кредитэд тулгуурласан; бодит зардал нь кредитийн тооноос хамааран өөрчлөгдөнө. *Пиерс Коллеж нь мужийн эсвэл коллежийн дотоод дүрэм болон бодлогод нийцүүлэх үүднээс урьдчилан мэдэгдэлгүйгээр төлбөр хураамжаа өөрчлөх эрхтэй.

Хэрхэн элсэх өргөдөл гаргах тухай

Бидний зорилго нь таны Пиерс Коллежод элсэх үйл явцыг аль болох хялбарчилж өгөх явдал юм. Элсэлтийн өргөдөл гаргах явцад танд асуулт гарвал бидэн рүү international@pierce.ctc.edu хаягаар и-мэйл бичээрэй. Бид танд ажлын нэг хоногийн дотор хариу өгнө. Элсэлтийн материалаа заавал бүрэн гүйцэд болгож байж илгээх шаардлагагүй. Өөрт байгаа материалаа бидэнд илгээвэл бид танд материалаа бүрдүүлэхэд тань туслалцаа үзүүлнэ.

1 Өргөдлийн маягт бөглөх

Манай www.pierce.ctc.edu/ie-apply вэбсайт хаяг дээрээс авах боломжтой

2 Бичиг баримтаа бүрдүүлэх:

- Гадаад паспортын хуулбар
- Коллежод элсэхэд at least \$20,000 USD ам.доллар, ЭСВЭЛ Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөрт (IEP) элсэхэд \$18,000 ам.доллартай тэнцэх үлдэгдэл бүхий банкнаас авсан албан ёсны тамгатай дансны хуулга
- Албан бус дүнгийн хуулга:
 - Академик түвшний сургалтанд шууд элсэх эсвэл Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөрт (IEP) элсэхэд ахлах сургууль төгссөн эсвэл коллеж/их дээд сургуульд суралцсан нотолгоо
 - Ахлах Сургуулийг Түргэвчлэн Төгсөх Хөтөлбөрт элсэхэд:
Ахлах сургуулийн дүнгийн хуулгыг Англи хэлээр орчуулж өгөх (9 ба түүнээс дээш анги эсхүл 14 наснаас эхлэх)
- Коллежод элсэн ороход Англи Хэлний Чадвараа Нотлох Баримт; TOEFL 61 эсвэл IELTS 5.5
Түүнчлэн бид дараах шалгалтуудыг хүлээн зөвшөөрдөг: Eiken 2-A, GTEC IBT 1050, ELS 109, EF B2-3 (Дэлгэрэнгүй мэдээллийг вэбсайтаас харна уу)
Англи Хэлний Эрчимжүүлсэн Хөтөлбөрт (IEP) хамрагдах бол Англи хэлний чадвараа нотлох шаардлагагүй

3 Өөрийн өргөдөл болон бичиг баримтуудыг international@pierce.ctc.edu и-мэйл хаягаар илгээнэ үү

4 Өргөдлийг Шалгах үйлчилгээний хураамж болон Шуудангийн хураамж төлөх (\$50) –бид танд хэрхэн төлөх зааварчилгааг илгээнэ

5 Таны Урилга болон Визний бичиг баримтуудыг (I-20) дараагийн ажлын өдөр тань руу шуудангаар илгээнэ

6 Бид танд визний ярилцлага, амьдрах байрны асуудлаар хүсэлт гаргах, сургууль танилцуулах өдөрлөгийн хуваарь болон таны Пиерс Коллежод амжилттай элсэн ороход шаардлагатай дараагийн алхмуудын талаар танд зааварчилгаа өгнө



#YouAreWelcomeHere

Сошиал медиагаар Пиерс Коллежийг дагаарай



piercecollegelE



piercecollegelE



piercecollegelE



PiercecollegelE



Одоо онлайнгаар элсэх өргөдөл гаргаарай!

www.pierce.ctc.edu/ie-apply



Дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд манай вэбсайт руу зочилно уу:

www.pierce.ctc.edu/IE

Бидэнтэй хэдийд ч хамаагүй холбогдоорой:

И-мэйл: international@pierce.ctc.edu

Утас: 253-964-6229

Факс: 253-964-6256

Байршил:

Pierce College International Education Office

9401 Farwest Drive SW

Lakewood, Washington 98498-1999, USA

1806 AF

Пиерс Коллеж нь өөрийн хөтөлбөр болон үйл ажиллагааны хүрээнд хэн нэгнийг арьс, өнгө, иргэншил, нас, бие эрхтэний болон оюун ухааны мэдрэгдсэн эсвэл бодит согог, жирэмслэлт, генетик мэдээлэл, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, гэрлэлтийн байдал, итгэл үнэмшил, шашин шүтлэг, чөлөөнд гарсан ахмад дайчин байх эсэх эсвэл цэргийн статус, дадлагажуулсан хөтөч нохой болон бусад үйлчилгээний амьтдын тусалцааг авдаг эсэхээс нь үл харгалзан ялгаварлан гадуурхдаггүй. Уг журмын хууль сахиулалтын талаар асуулт байгаа Pierce College District Title IX Coordinator, 253-964-6519 | 9401 Farwest Drive SW, Lakewood WA 98498 хаягаар холбогдоорой.

Пиерс Коллеж нь Эрх Тэгш, Олон Талт болон Нийтийг Хамарсан Байдлыг дэмжих үүрэг амлалт хүлээсэн бөгөөд шаардагдах туслах төхөөрөмж байгаагүй эсвэл үйлчилгээ авч чадаагүйн улмаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигдөхгүй байхад онцгой анхаардаг. Бид коллежоос санхүүжүүлсэн бүх үйл ажиллагаануудад боломжит тохируулгуудыг санал болгодог. Хэрэв танд тохируулга хэрэгтэй эсвэл санал болгож буй шаардагдах туслах төхөөрөмжүүдийн талаар асуулт байгаа бол, Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Тусламж, Үйлчилгээнд 253-964-6468 дугаараар эсвэл ADS@pierce.ctc.edu хаягаар холбогдоорой. Тухайн арга хэмжээнээс дор хаяж 2 долоо хоногийн өмнө мэдэгдсэн хүсэлтүүд хамгийн үр дүнтэйгээр шийдвэрлэгддэг болохыг анхаарна уу.